



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021 • III • № 55



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН
САНГААС: "ЦАГААН АРСЛАН" ОДОН

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг хэвээр хадгалах, санхүүжилтийн хэмжээний тухай

Дугаар: 2021/01

Огноо: 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны төлөв байдал, эрсдэлийг харгалзан үзээд санхүүгийн нөхцлийг үргэлжлүүлэн зөөлрүүлэх зорилгоор: 1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах; 2. Урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 2-р улиралд 350 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа. Уг санхүүжилтийг боловсруулах, үйлчилгээ болон 200 дээш ажиллагчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулахаар өргөтгөв. Жилийн инфляц 2021 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 2.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 2.0 хувьтай байна. Эрэлтийн хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө ирэх улирлуудад эдийн засгийн идэвхжлийг даган аажмаар нэмэгдэх бол шатахуун, сайжруулсан түлшний үнийн нөлөөгөөр нийлүүлэлтийн шалтгаантай инфляц цаашид өсөхөөр байна.

Суурь төсөөллөөр 2021 онд инфляц дунд хугацааны зорилтын орчимд хадгалагдах хүлээлттэй байгаа хэдий ч вирусн тархалт, вакцинжуулалттай холбоотой өөрчлөгдөж болзошгүй байна. Вакцинжуулалт амжилттай үргэлжлэх тохиолдолд эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, аж, ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх хүлээлт хэвээр байна. 2021 оны эхний 2 сард экспорт 73 хувиар, боловсруулах салбар 1, 2 дугаар саруудад 66 хувь болон 37 хувиар тус тус өслөө. Түүнчлэн, олон улсын зээлжих зэрэглэлийн Мүүдис агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг сөргөөс тогтвортой болгож сайжруулахад Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хүрэлцээ нэмэгдэж, богино хугацаат гадаад өрийн дарамт буурсны зэрэгцээ эдийн засгийн төлөв сайжрах хүлээлттэй байгаа нь нөлөөлсөн байна. Төв банкны зүгээс КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах шат дараатай авч хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд, шинээр нэвтрүүлж буй санхүүжилтийн хэрэгслүүд нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалж байна. Инфляц зорилтоос давах нөхцөл үүссэн тохиолдолд Мөнгөний бодлогын хороо бодлогын тохируулга хийх болно. Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-
ЭРДЭНЭ БАНК,
САНХҮҮГИЙН
САЛБАРЫН
ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАВ



06

ЯРИЛЦЛАГА

Ч.ХАШЧУЛУУН:
ЭДИЙН ЗАСАГТ ЗЕРЭГ
ӨӨРЧЛӨЛТҮҮД ГАРЧ
БАЙНА



09

**ЭДИЙН ЗАСАГ
ЭНГИЙНЭЭР**

ИНФЛЯЦЫН
ТАЙЛАНГИЙН
НЭГДҮГЭЭР
УЛИРЛЫН ТОЙМ



11

АСУУЛТ, ХАРИУЛТ


МОНГОЛБАНКНЫ
ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРЛААС



19

**ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ,
ХАРИУЛТ**

“АЖЛЫН БАЙРЫГ
ДЭМЖИХ ЗЭЭЛ”-ИЙН
ТУХАЙ ТҮГЭЭМЭЛ
АСУУЛТ, ХАРИУЛТ



21

**МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ**

ВИРТУАЛ ХӨРӨНГӨ
ГЭЖ ЮУ ВЭ?

27

СУДАЛГАА

ЭДИЙН ЗАСГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, АЖ
ҮЙЛДВЭРИЙН
БОДЛОГО: БУСАД
ОРНЫ ТУРШЛАГААС
СУРАЛЦАХУЙ



31

БАНКИР

МАРКУС ЛОХ: САЙН
ЭДИЙН ЗАСГИЙГ
БҮРДҮҮЛЭХЭД
ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ ЧУХАЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАВ



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ тэргүүтэй Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны удирдлагууд бүхий төлөөлөл банк, санхүүгийн салбарынхантай уулзалт хийлээ. Энэ үеэр МҮЕС Л. Оюун-Эрдэнэ Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгасан 2 их наяд төгрөгийн зээлийг жижиг, дунд бизнес, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдэд 3%-ийн хүүтэйгээр банкуудаар дамжуулж олгох, хүүгийн зөрүүг төрөөс даах болсон тухай танилцуулж, банкуудтай хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцлоо. Банкны салбарын төлөөллүүдийн энэ үеэр төрөөс тавьж буй шаардлага ил, тод, хүнд сурталгүй байх, цахим хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зээлдэгчдээ эрсдэлээс хамгаалах хяналтын тогтолцоо бүрдүүлэх, зээлдэгчдэд тавих шаардлагыг багасгах зэрэг асуудал чухал байгааг дурдав.

“ҮХЭР ЖИЛ” ДУРСГАЛЫН МӨНГӨН ЗООС ХУДАЛДААЛЖ ЭХЭЛЛЭЭ



Монголбанкны Эрдэнэсийн сангаас 2021 онд Цөөвөр хэмээх цагаагчин үхэр жилд зориулан 1 унцын 999 сорьцтой “Үхэр жил” мөнгөн зоосыг худалдаанд гаргалаа. Тус дурсгалын зоосыг хамгийн сүүлийн үеийн Smartminting технологиор урлаж, хэсэгчлэн алтаар бүрсэн байна.

МҮҮДИС АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ТӨЛӨВИЙГ “СӨРӨГ” БАЙСНААС “ТОГТВОРТОЙ” БОЛГОН САЙЖРУУЛЛАА




Мүүдис агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B3” хэвээр үлдээж, төлөвийг “сөрөг” байсныг “Тогтвортой” болгож сайжруулсан тухай 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зарлалаа. Тус байгууллагын дүгнэлтээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахлын нөлөөгөөр буурах үзүүлэлттэй байгааг төрөөс цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй бодлого, төсвийн тогтвортой байдал, эрдэс баялгийн түүхийн эдийн зах зээлд үнийн эерэг өөрчлөлт, таатай нөхцөл байдал үүссэн зэрэг үндэслэлүүдээр тогтворжиж эхэлсэн гэдгийг хэвлэлийн мэдээндээ тэмдэглэжээ.

МОНГОЛБАНК РЕПО АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАМРАГДАХ САЛБАРЫГ ӨРГӨТГӨЛӨӨ



Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдаанаар урт хугацаант репо санхүүжилтийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, хамрагдах салбарыг өргөтгөх шийдвэрийг гаргалаа. Үүнд: санхүүжилтийн хэмжээг 350 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, зээлийн дээд хэмжээг 3 тэрбум төгрөг хэвээр үлдээх, Хамрагдах салбарт үйлчилгээ (Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа; Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа; Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа; Урлаг, үзвэр, тоглоом, наадам зэрэг салбарууд хамаарна), боловсруулах үйлдвэрлэл, хоёр зуу болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарыг нэмж хамрууллаа.

"БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ НЬ" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ БОЛОО



Монголбанкнаас Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай хамтран хэрэгжүүлж буй Европын холбооны дэмжлэгтэй "Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулах" төслийг дүгнэх олон улсын бага хурал 3-р сарын 22-ны өдөр цахимаар боллоо. Тус хурлаар "БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ" судалгааны үр дүн, сургагч багш бэлтгэх сургалт, БЖДҮ эрхлэгчдэд Санхүүгийн боловсрол олгох стратеги, бизнес эрхлэгчдэд сургалт орсон үйл явц сэдэвт танилцуулгууд хийгдэв. Хурлын төгсгөлд БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох 32 багш нарыг бэлтгэх сургалтын болон батламж гардуулах видео танилцуулгыг хийсний зэрэгцээ "Дэлхийн мөнгөний долоо хоног 2021" аяныг Монгол Улсад нээж байгааг зарлалаа.

"ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2021" АЯНЫГ НЭЭВ



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ээс зохион байгуулдаг "Дэлхийн Мөнгөний Долоо Хоног" аяны нээлтийг 3-р сарын 22-ны өдөр цахимаар хийлээ. Хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, үүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготойгоор жил бүр болдог тус аяныг энэ жил дэлхий нийтээр "Суралц-Хуримтлуул-Өсгө" уриан дор тэмдэглэж байна. Монголбанк 2013 оноос холбогдох байгууллагуудтай хамт энэхүү аянд нэгджээ.

Манай улс эдгээр өдрүүдэд "Мөнгөө хэрхэн удирдах вэ", "Хувь хүний санхүү ба өрхийн төсөв", "Зардал ба хуримтлал", "Цахим мөнгө" зэрэг сэдвээр сургалт, мэдээллүүдийг өгч байна.

"САНСАР-40 ЖИЛ" ДУРСГАЛЫН МӨНГӨН ЗООС ГАРГАЛАА



Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын баатар, Чингис хаан одонт, хошууч генерал Ж.Гүррагчаа, Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал, академич С.Дэмбэрэл нарыг хүлээн авч уулзлаа. Монголбанкны Эрдэнэсийн сангаас уг ойг тохиолдуулан "Сансар-40 жил" дурсгалын зоосыг шинээр эрхлэн гаргасан бөгөөд уулзалтын үеэр Ж.Гүррагчаа баатарт уг дурсгалын зоосны дээжийг гардуулан өгөв.

"Сансар-40 жил" зоос нь сансрын уудам байдлыг "obsidian black" технологи ашиглан хар өнгөөр харуулж, сар болон дэлхийг өнгөтөөр дүрсэлжээ.

Ч.ХАШЧУЛУУН: ЭДИЙН ЗАСАГТ ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТҮҮД ГАРЧ БАЙНА



Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2021 оны эхний улирлын хурлаа 3-р сарын 24-ний өдөр хийж, бодлогын хүүг 6%-д хэвээр үлдээх, урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 2-р улиралд 350 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргасан.

Үүнтэй холбоотойгоор Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүн Ч.Хашчулууны 3-р сарын 25-ны өдөр Bloomberg TV Mongolia телевизээр илэрхийлсэн байр суурийг хүргэж байна.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг "тогтвортой" болгож өөрчилсөн. Үүнээс гадна Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 6%-д хэвээр хадгалах шийдвэр гаргаад байна. Та хорооны гишүүний хувьд Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэлүүдийг хэрхэн тодорхойлсон талаар мэдээлэл өгнө үү?

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн үндэслэлийг харвал юуны өмнө эдийн засгийн сэргэлт идэвхжиж эхэлж байгаа тоо баримтууд гарч ирж

байна. Тухайлбал уул уурхай, боловсруулах салбарт нэлээд өсөлт гарлаа. Цаашид энэхүү эерэг "момент" хадгалагдвал бид хямралаас хурдан хугацаанд гарах буюу 2021 оны 1-р улиралд эдийн засгийн өсөлт жилийн дүнгээр 6% хүрч магадгүй гэсэн урьдчилсан таамаглал бий. Нөгөө талаас экспорт сайжирч буйтай холбоотой төсвийн орлого өмнөх оны мөн үеэсээ 17 хувиар өсөөд байна. Боловсруулах салбарт ч өндөр өсөлт гарсан.

Мөн Монголбанкнаас ₮166 тэрбумыг репо санхүүжилтийн хүрээнд жижиг дунд

үйлдвэрүүдэд олгоод байна. Цаашид ₮350 тэрбумыг олгохоор зэхэж байгаа юм. Энэ бүхнийг авч үзвэл эдийн засагт эерэг өөрчлөлт гарлаа гэж дүгнэж байна.

2021 онд дотоодын эдийн засаг 6.1% өсөж, инфляц 7% байх таамаглал гараад байна. Инфляцын дарамт нэмэгдвэл мөнгөний бодлогыг чангаруулах уу?

Одоохондоо шууд ярихад арай эрт байна. Мэдээж эдийн засгийн сэргэлт идэвхтэй байвал худалдан авалт, импорт, гадаад

валютын эрэлт өсөх байх. Тийм учраас үнийн тогтвортой байдлыг хадгалах, инфляцыг нам түвшинд байлгах үүднээс дараа дараагийн улирлуудад тийм шийдвэр гарахыг үгүйсгэхгүй. Бид хэвийн байдал руу орж байна гэсэн үг.

Сүүлд болсон Мөнгөний бодлогын хорооны хурлаар өөр ямар том асуудал, эдийн засагт үүсэж болох эрсдэлүүдийн талаар ярилцсан бэ?

Мэдээж эдийн засагт эрсдэлүүд их байгаа. Юуны өмнө тодорхой бус байдлыг харвал Ковид-19-ийн тархалт дуусаагүй, орон нутагт өвчлөл гарч байна. Хөл хорио тогтоохтой холбоотой өрхийн хэрэглээнд томоохон өөрчлөлтүүд гарах зэрэг эрсдэл бий. Ер нь Монгол Улсад тавьж буй хөл хорионы дэглэм дэлхийд хамгийн хатууд орж байгааг олон улсын судалгаа харуулсан. Мөн эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байгааг уг судалгаанд дүгнэсэн байсан. Тиймээс үүнтэй холбоотой эрсдэл байгааг санах хэрэгтэй.

Засгийн газрын эдийн засгаа дэмжих ₮10 их наядын хөтөлбөрийн хэрэгжилтэд бизнесийнхэн хүлээлт өндөртэй байна. Хэрэгжилт оновчтой байхад ямар алхмууд хамгийн чухал вэ?

Хүлээлтийг зөв удирдах нь чухал. Нэгдүгээрт ₮10 их наяд гэдэг нь 2-3 жилд хэрэгжих дүн. Шууд нэг сарын дотор ирж ирж байгаа

мөнгө биш. Харин төсөв болон банкны системээр дамжуулж эдийн засгийг тэтгэж буй санхүүжилт юм. Тиймээс төслүүд нь гарч ирж санхүүжигдээд, үйлдвэрүүд байгуулагдтал хугацаа бий гэдгийг шууд хэлэх хэрэгтэй. Тиймээс өдөр, сарын дотор шууд үр дүн өгнө гэсэн гэнэн байдлаар хандаж болохгүй.

Харин алхам алхмаар эдийн засаг сайжирна гэж харж байна. Юуны өмнө экспорт, төсвийн орлого сайжирч байгааг анхааралдаа авч, Оюу толгойн хэлэлцээ амжилттай болбол 2022 оноос эдийн засгийн өсөлт өндөр байх боломжууд бий. Тиймээс удирдлага, төлөвлөлтөө сайн хийж, хүлээлтээ зөв удирдах ёстой болов уу гэж бодож байна.

“

Юуны өмнө экспорт, төсвийн орлого сайжирч байгааг анхааралдаа авч, Оюу толгойн хэлэлцээ амжилттай болбол 2022 оноос эдийн засгийн өсөлт өндөр байх боломжууд бий

”

2021 оны эхнээс 04.01-ний өдөр хүртэл

НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛ

200.0
тэрбум төг
1,414
зээлдэгч



- ААН:
159.4 тэрбум, 1,091 зээл

- Шинэ зээл:
41.4 тэрбум, 233 зээл

- Иргэн:
40.6 тэрбум, 323 зээл

- Дахин санхүүжилт:
158.6 тэрбум, 1,178 зээл

Нийт зээлийн хүсэлт:

451.8 тэрбум,
2,144 хүсэлт

Судалгаанд байгаа:
387 хүсэлт

Судалгаанд ороогүй:
0 хүсэлт

Татгалзсан:
343 хүсэлт

БАНКУУДЫН ЗЭЭЛ ОЛГОЛТ

		Дүн	Тоо
Хаан		99.8	858
ХХБ		29.6	169
Голомт		21.0	143
Хас		17.7	117
Капитрон		18.3	78
Богд		7.0	34
ТХБ		4.3	6
Төрийн банк		2.1	9

Зээлдэгчийн ажлын байр:

12,691

(зээл олгох үеийн байдлаар)

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН СТАТИСТИК

2021 оны эхнээс 04.01-ний өдөр хүртэл

НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛ

179.2
тэрбум төг
2,391
зээлдэгч



- Шинэ зээл:
165.2 тэрбум, 2,141 зээл

- Дахин санхүүжилт:
14.0 тэрбум, 250 зээл

Нийт зээлийн хүсэлт:

453.8 тэрбум,
6,504 хүсэлт

Судалгаанд байгаа:
2,635 хүсэлт

Судалгаанд ороогүй:
49 хүсэлт

Татгалзсан:
1,429 хүсэлт

БАНКУУДЫН ЗЭЭЛ ОЛГОЛТ

		Дүн	Тоо			Дүн	Тоо
ХХБ		60.0	738	Капитрон		9.6	139
Хаан		43.6	643	Богд		2.1	31
Голомт		30.8	393	Кредит		0.6	7
Төрийн		19.5	234	ТХБ		0.15	2
Хас		12.5	204				

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК

2021 оны 3.10-ны өдрөөс 04.01-ний өдөр хүртэл

НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛ

288.5
тэрбум төг
4,237
зээлдэгч



- ААН:
152.4 тэрбум, 651 зээл

- Шинэ зээл:
278.5 тэрбум, 4,112 зээл

- Иргэн:
136.2 тэрбум, 3,586 зээл

- Дахин санхүүжилт:
10.0 тэрбум, 125 зээл

Нийт зээлийн хүсэлт:

4,677.1 тэрбум,
34,743 хүсэлт

Судалгаанд байгаа:
10,990 хүсэлт

Судалгаанд ороогүй:
22,540 хүсэлт

Татгалзсан:
1,213 хүсэлт

БАНКУУДЫН ЗЭЭЛ ОЛГОЛТ

Банкны нэр		Дүн	Хувь	Тоо
Хаан		206.7	71.6%	2,717
Төрийн		48.6	16.8%	1,149
Голомт		16.0	5.5%	62
Хас банк		12.1	4.2%	287
Худалдаа хөгжлийн		4.3	1.5%	16
Кредит		0.5	0.2%	1
Капитрон		0.3	0.1%	5
Нийт		288.5	100.0%	4,237

Зээлдэгчийн ажлын байр:

14,671

(зээл олгох үеийн байдлаар)

Улаанбаатар хотод:
10,540

Орон нутагт:
4,131



ИНФЛЯЦЫН

ТАЙЛАНГИЙН НЭГДҮГЭЭР

УЛИРЛЫН ТОЙМ

Гадаад эдийн засгийн орчин сайжирч, Засгийн газар, Төв банкнаас эрэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа хэдий ч дотоод эдийн засаг 2021 онд алгуур сэргэх хүлээлт хэвээр байна. Инфляцыг бууруулах чиглэлд нөлөөлж буй нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө арилах, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн төсөөлөл өссөн зэргээс инфляц цаашид нэмэгдэхээр байна.

Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө ирэх саруудад нэмэгдэхээр байна. 2021 оны 2 дугаар сард инфляц улсын хэмжээнд 2.6 хувь, Улаанбаатар хотод 2.0 хувьд хүрэв. Махны үнэ 2-р сард улирлын хандлагаасаа давж өссөн ч сайжруулсан түлшний үнийг 75 хувь хөнгөлсөн нөлөөгөөр нийлүүлэлтийн шалтгаантай инфляц 1-р улирлыг дуустал бага байх төлөвтэй. Харин 2-р улирлаас нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэхэд; 1) инфляцыг 1 нэгж орчим хувиар бууруулж байгаа шатахууны үнийн суурь үеийн нөлөө арилах, 2) сайжруулсан түлшийг хөнгөлөлттэй үнээр худалдаалах Засгийн газрын

шийдвэрийн хэрэгжих хугацаа 4-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болох зэрэг нь голлон нөлөөлөхөөр байна. Эрэлтийн хүчин зүйлсийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө нь эдийн засгийн идэвхжлийг даган аажмаар нэмэгдэх хандлагатай байна. Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл 2021 онд инфляц төв банкны зорилтот түвшний интервалд ($6\% \pm 2\%$) хадгалагдах хүлээлттэй байна.

КОВИД-19 цар тахал дотоодод тархсан нь эдийн засгийн сэргэлтийг удаашруулж, 2021 оны эхний хагаст уул уурхайн бус салбарын идэвхжил төдийлөн нэмэгдэхээргүй байна. Эдийн засгийн өсөлт 2020 онд төсөөллийн орчимд байлаа. 2021 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнээр уул уурхайн салбар эрчимжих бол цар тахлын сөрөг нөлөө уул уурхайн бус салбарт хүлээлтээс өндөр байна. Улаанбаатар хотод вирусын тархалт нэмэгдэж 2021 оны 2-р сарын 11-ний өдрөөс 23-ны өдрийн хооронд бүх нийтийн бэлэн байдалд шилжин, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон нь 1-р улирлын уул уурхайн бус салбарын өсөлтийг

сааруулах нөлөөтэй. Түүнчлэн, КОВИД-19-ийг бүрэн хяналтад оруулах хугацаа удааширч, тархах хүрээ нь тэлж байгаа тул энэ оны 2-р улиралд уул уурхайн бус салбар хэвийн түвшинд хүрч сэргэхээргүй байна. Уул уурхайн салбарын хувьд хилийн бүс нутгуудад халдвар тархахгүй, экспорт хэвийн явагдах тохиолдолд тус салбар 2021 онд өндөр өсөлттэй байх төлөвтэй. Эдийн засгийн цаашдын төлөв хэрхэн өөрчлөгдөх нь дотоодод тархсан КОВИД-19 вирусыг хяналтдаа оруулах хугацаанаас голлон хамаарч байна.

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2020 оны 2 дугаар улирлаас алгуур нэмэгдэж, энэ оны 1-р сард 18 хувьд хүрлээ. Өмнөх онд төсвийн алдагдал тэлж, шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн идэвхжил сул, зах зээлийн эрсдэл өндөр байсан нь банкны системийн зээлийн өсөлтийг хязгаарлаж, зээлийн өсөлт 2020 оны турш нам түвшинд хадгалагдлаа. Харин ирэх улирлуудад эдийн засгийн сэргэлтийг даган зээлийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна.

Дэлхий нийтээр цар тахлын эсрэг вакцинжуулалт эхэлж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Томоохон эдийн засагтай орнуудын 2020 оны 4-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарсны дээр БНХАУ, АНУ-ын 2021 оны өсөлтийн төсөөлөл нэмэгдлээ. Хэдийгээр гадаад орчинд цар тахлын шинэ давалгаанууд үүсч дэлхийн эдийн засгийн Инфляцын тайлан 2021 оны 3-р сар 5 идэвхжилд сэргөөр нөлөөлж

байгаа боловч тархалтыг хяналтад оруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийн хүлээлт харьцангуй өөдрөг хэвээр байна. Цаашид КОВИД-19 вирусын эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байна.

Төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.доллар буюу ДНБ -ий 9.6 хувьтай тэнцэх ашигтай гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1071 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болж, улмаар жилийн дүнгээр төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай байв. Тодруулбал, 2020 оны 4-р улиралд экспорт сэргэж, импорт агшиж, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 165.4 сая ам.долларын ашигтай гарсны дээр гадаад зээлийн ашиглалт нэмэгдэж, ГШХО-аас бусад хөрөнгө оруулалтын орох урсгал өссөн нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлжээ. Энэ онд түүхий эдийн үнэ өндөр байгаа нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөтэй ч дотоодод вирус тархсан нь улс хоорондын ачаа тээврийг хязгаарлаж, улмаар экспорт удаашрах эрсдэлийг үүсгэж байна. Гадаад худалдааны нөхцөл 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар сайжирлаа. Экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 3.1 хувиар буурчээ. Гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирсан бөгөөд үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС

Мөнгөний бодлогын хороо 2021.03.24-ний өдөр хуралдаж, бодлогын хүүг хэвээр хадгалах, репо санхүүжилтийн хүрээнд хоёрдугаар улиралд 350 тэрбум төгрөгийг олгох, репо санхүүжилтийн хүрээг тэлж, 250-аас дээш ажилтантай үйлчилгээний салбарыг хамруулах шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын мэдэгдлийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариулав.

NTV: Репо санхүүжилтийн хэмжээг 350 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх болсны гол шалтгаан нь юу вэ. Улиралдаа 250 тэрбум төгрөг олгохоор байсныг нэмэгдүүлж, 500 тэрбум төгрөг болгоно гэж Ерөнхий сайд хэлж байсан. Тэгэхээр төв банкны хувьд энэ дагуу репо санхүүжилтийн дүнг нэмэгдүүлж байна гэж ойлгож болох уу?

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Г.ДӨЛГӨӨН:

Репо санхүүжилтийн хувьд банкууд руу санхүүжилтийг 6.5 хувь буюу бодлогын хүүн дээр 0.5 пунктээр олгож байгаа. Зөрүү 4 хувь дээр нь банкууд өөрсдийн үйл ажиллагааны зардлаа нэмснээр 10.5 хувийн хүүтэйгээр зээлдэгчдэд хүрч байгаа бөгөөд уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих

зорилготой санхүүжилт юм. Үүний нөгөө талд 10 их наядын төлөвлөгөөний дагуу ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээлийг олгож эхэлсэн. Үүгээр иргэнд 50 сая, аж ахуйн нэгжүүдэд 500 сая төгрөг хүртэл олгож байгаа. Энэхүү зээлийн хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх Төв банк, Сангийн яам, СЗХ, ХДК буюу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдаж, шийдвэр гаргасан. Зөвлөлөөс хяналтын ажлын хэсэг гарч, өдөр тутмын мэдээн дээр анализ хийж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа. Репо санхүүжилтийн дүнг улирал бүр мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, өмнөх улирлын гүйцэтгэлтэйгээр уялдан өсөх схемээр явж байгаа гэдгийг хэлье. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 10 их наядын төлөвлөгөөнд багтсан суурь дүнгээр энэ жилдээ багтааж 3 хүртэлх их наяд төгрөгийн репо санхүүжилтийг олгох төлөвлөгөөтэй ажиллаж байна. Репо санхүүжилтийг

хэрэгжүүлж эхэлснээс хойш одоогоор 830 тэрбум төгрөгийг олгоод байна.

Ийгл ТВ: Бодлогын хүүг өнгөрсөн онд 5 нэгж хувиар бууруулсан. Тэгэхээр одоо үр дүн нь гараад эхэлсэн байх ёстой. Эдийн засагт ямар эерэг өөрчлөлт гарсан бэ? Үүний нөгөө талд ТБҮЦ-ны дүн 70 хувиар нэмэгдсэн байсан. ТБҮЦ-ны үлдэгдэл бодлогын хүүтэй уялдахгүй байгааг юу гэж ойлгох вэ?

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Г.ДӨЛГӨӨН:

Бодлогын хүүг өнгөрсөн жилийн хугацаанд ээлжит болон ээлжит бус хурлуудаар нийтдээ 5 нэгж хувиар бууруулсан. Өнөөдөр хэвээр үлдээх шийдвэр гаргасан. Бодлогын хүүг би өөр өнцгөөр тайлбарлая. Тэгэхээр инфляц улсын хэмжээнд 2 орчим хувьтай байна. Үүний нөгөө талд манай улсын төгрөгийн ханшийн сулралт өнгөрсөн жил харьцангуй гайгүй байсныг та бүхэн ажигласан байх. Жилдээ 6-7 хувь, эдийн засаг хүндрэлтэй байх үед 10 хувиар ханш сулрах тохиолдол гардаг. Өнгөрсөн жил хөл хорио тавигдсан, хил хаагдсантай холбоотой сөрөг нөлөөллүүд гарсан. Мөн алт тушаалт нэмэгдсэн, нүүрсний үнэ өссөн, Оюутолгойн баяжмалын агуулга нэмэгдсэн зэрэг эерэг нөлөөллүүд ч бий. Ийм нөхцөлд төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байлаа. Өнөөдрийн бодлогын хүүг тодорхойлж байгаа 6 хувийн 2 хувь нь инфляц, үлдсэн 4.4 хувь нь төгрөгийн ханшийн сулралтай холбоотой. Тэгэхээр үндсэндээ төгрөг өнгөрсөн жил 6.5 орчим хувиар суларсан гэж ойлгох хэрэгтэй. Тийм учраас бодлогын хүүг одоо 6 хувиас доош бууруулах орон зай байхгүй. Мөн Төв банкны тухай хуулиар төв банкны үндсэн чиг үүрэг нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах. Бид энэ үндсэн чиг үүргийг хангахын төлөө ажиллаж байгаа учраас яаран шийдвэр гаргах нь эрсдэлтэй гэж үзэж байгаа. Банкуудын актив талдаа 50 хувьд нь зээл гардаг бол үлдсэн 50 хувиараа ТБҮЦ авах болон бусад төрлийн активуудад байршуулдаг. Бодлогын хүүг бууруулснаар банкууд активаа ТБҮЦ-нд байршуулах тал дээр зардлын хувьд маш том өөрчлөлтийг бий болгосон учраас пассив талдаа зохицуулалт хийж, хадгаламжийн хүүгээ бууруулж ирсэн. Энэ нь төгрөгийн үнэлгээ тэр хэмжээгээр буурч байна гэсэн үг. Төгрөгөөр хадгаламж эзэмшиж байгаа хүмүүст сөрөг нөлөөтэй. Тэгэхээр бид инфляц, ханштайгаа уялдан бодлогын хүүг байж болох хамгийн доод түвшинд нь барьж байгаа. Сая дурдсан

үзүүлэлтүүд дээр тодорхой нөлөөллүүд гарсан. Хамгийн тод жишээ нь оны өмнө системийн 30 хувийг эзэлдэг Хаан банк хадгаламжийн хүүгээ 9.8 хувь гэж зарлалаа. Өнөөдөр Төрийн банк хамгийн бага буюу 8.6 хувиар хадгаламжийн хүүгээ зарлаж байна. Энэ нь актив талдаа бизнесүүдэд очих зээлийн хүү тэр хэмжээгээр буурна гэсэн үг.

Ийгл ТВ: Ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээлийн тухайд банкуудын зээл олгох сонирхол ямар байгаа вэ?

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Г.ДӨЛГӨӨН:

Бид бүхэн зээл олголттой холбоотойгоор өдөр бүр мэдээг авч байгаа. Өнөөдрийн байдлаар 57 иргэн, аж ахуйн нэгжид 200 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Энэ хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө банкууд бүгд Засгийн газраас хэрэгжүүлэх төлөвлөгөөнд оролцоно гэдгээ илэрхийлж, иргэн, аж ахуйн нэгжүүдээс хүсэлтийг нь авч эхэлсэн. Арилжааны банк, Сангийн яам, Монголбанк, Зээлийн батлан даалтын сангийн хооронд ерөнхий гэрээ байгуулж, холбогдох шаардлагуудыг тавьсан. Хамгийн гол шаардлага нь аж ахуйн нэгжийн хувьд НӨАТ төлөгч байх. Иргэдийн хувьд тодорхой шаардлагуудыг бууруулж өгсөн. Гэхдээ нөгөө талдаа банкууд өөрсдөө эрсдэлээ хүлээж байгаа учраас тодорхой шаардлагыг тавьж байгааг үгүйсгэхгүй. Хамгийн гол нь энэ төлөвлөгөөний дагуу аж ахуйн нэгж, иргэдэд очих зээл нь ажлын байрыг хадгалах нөхцөлтэй байх ёстой. Түүнээс биш ямар нэгэн барилга, байшин худалдаж авах, хэрэглээний зүйлд зориулагдаагүй. Хэрвээ зориулалтын бусаар ашиглавал ерөнхий гэрээний дагуу уг зээлийг шууд арилжааны нөхцөл рүү шилжүүлэх хүртэл арга хэмжээг ярьж байгаа. Гол нь бид бүхэн энэ зээл авах ёстой эзэндээ очоосой гэдгийг зорьж байна.

МҮОНТ: Зээлийн жигнэсэн дундаж хүү хэдэн хувьтай байна вэ?

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Г.ДӨЛГӨӨН:

Зээлийн жигнэсэн дундаж хүү одоогоор 14.5 хувьтай байгаа. Мөн 10 их наядын төлөвлөгөө болон репо санхүүжилтийн хүрээнд олгогдож байгаа зээлүүд зээлийн багцад тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлж

байгаа. Бид Зээлийн хүүг бууруулах стратегийг өнгөрсөн жил Их Хурлаар батлуулсан. Үүний хүрээнд холбогдох дүрэм, журмуудад өөрчлөлт орж байгаа. Хамгийн том өөрчлөлт нь өнгөрсөн жилийн намрын чуулганаар Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнтэй холбоотойгоор холбогдох дүрэм, журамд өөрчлөлт орж, Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх ажлын хэсэг тодорхой давтамжтайгаар хуралдаж, үр дүнгүүдээ харж байгаа. Тухайн үед стратеги төлөвлөгөө батлагдаж байх үетэй харьцуулахад зээлийн хүү 3-4 пунктээр буусан гэж бид бүхэн харж байгаа. Гэхдээ мэдээж ганц стратеги төлөвлөгөө хэрэгжсэнээр зээлийн хүү буурах гол хүчин зүйл болохгүй. Зээлийн хүүг бууруулах стратеги төлөвлөгөөний гол зорилго нь банкууд дээр үүсээд буй хөөсөрсөн, журмын гажуудал гарсан, үрэлгэн зардлуудыг бууруулснаар зээлийн хүүг бууруулна гэдэг зорилгыг тавьсан. Түүнээс биш захиргаадлын аргаар зээлийн хүүг бууруулахгүй.

Блүүмбэрг ТВ: Эдийн засгийн шинэчилсэн төсөөллөө танилцуулна уу?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.БАЯРДАВАА:

Эдийн засгийн өсөлтийн шинэчилсэн төсөөллийг 2021 оны хувьд 6.1 хувиар тооцож байгаа. Үүнд уул уурхайн болон уул уурхайн бус салбарын өсөлтүүд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Мэдээж дотооддоо цар тахлын нөхцөл байдлаас хамаарах нь ойлгомжтой. Оны эхний хагаст уул уурхайн салбарт нэлээд том өсөлт бий болох хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, бид нэгдүгээр улиралд 30 орчим хувиар, хоёрдугаар улиралд 50 орчим хувиар өсөх болов уу гэж хүлээж байна. Уул уурхайн бус салбарын өсөлт өнгөрсөн оны 4 дүгээр улирлын эцэс -5.7 хувь байсан. Энэ агшилт нэгдүгээр улиралд дор хаяж 0 хувь руу ирэх буюу агшилт зогсох болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Улмаар хоёрдугаар улиралд 2.8 хувьтай, гуравдугаар улиралд 4.5 хувь, дөрөвдүгээр улиралд 6 хувьд хүрч өснө гэж үзэж байна.

Gogo.mn: Дэлхийн эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэлсэн нь Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ?

Америк, Хятад зэрэг манай худалдааны гол түнш, гадаад эрэлтийг тодорхойлдог эдийн засгуудад эерэг өөрчлөлт гарч байна. 2020 оны гүйцэтгэл бидний хүлээж байснаас сайн гарсан. 2021 оны эдийн засгийн өсөлтийг олон янзын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын банкууд шинэчилж тооцохдоо өмнөхөөсөө

сайжруулсан байна. Холбооны нөөцийн банк АНУ-ын эдийн засгийг 6.5 хувиар өснө гэсэн төсөөллийг танилцууллаа. Бусад эх сурвалжууд 4-5 хувиар өснө гэж төсөөлж байсан. Хятадын эдийн засаг дунджаар 8 гаруй хувьтай өсөх төсөөлөлтэй байна. Гадаад орчинд үүсч байгаа эерэг хандлага нь Монголын эдийн засагт экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнээр дамжиж эерэг нөлөө үзүүлнэ. Өнөөдрийн байдлаар нүүрс, зэсийн экспорт удааширсан байгаа ч бид үүнийг түр зуурынх гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл, энэ нь богино хугацаандаа шийдвэрлэгдэх бололцоотой. Үүний үр дүнд уул уурхайн салбарт өсөлтүүд бий болно. Энэ бол гадаад эдийн засгийн Монгол руу дамжиж орж ирэх нэг эерэг нөлөө. Нөгөө талаас гадаад эдийн засгийн таатай орчин хүлээгдэж байгаа үед экспортын үнээс гадна бид төлбөрийн төлбөрийн тэнцэл дээр эерэг нөлөөллийг авна. Төлбөрийн тэнцэл нь гадаад валютын нөөц, төгрөгт итгэх итгэл, төсвийн орлого, төсвийн тэнцэл зэрэг олон зүйл эерэг нөлөө үзүүлж байгаа. Энэ байдал нь дотоод эдийн засагт итгэх итгэлийг сайжруулна. Та бүхэн санаж байгаа бол өнгөрсөн долоо хоногт Moody's агентлаг Монголын эдийн засгийн төлөвийг сөргөөс тогтвортой болгож, сайжруулсан. Энэ нь хөрөнгө оруулагчид Монголын эдийн засгийн талаар эерэг хүлээлттэй байна гэдгийг илэрхийлж байна. Үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэж байна. Мөн богино хугацаат гадаад өрийн дахин санхүүжилтүүд амжилттай хийгдсэн. Төсөв, мөнгөний бодлого, санхүүгийн зохицуулалтууд нь эдийн засгийг ковидын сөрөг нөлөөллөөс ангижруулахад үр дүнтэй байна. Эдийн засгийн өсөлт эерэг хандлагатай байна зэрэг нь нөлөөлж байна.

Мөнгөний бодлогын мэдэгдэлд нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өснө гэсэн байна. Инфляц яг хэдэн хувьд хүрэх вэ, Монголбанк ямар хариу үйлдэл үзүүлэх вэ?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Нийлүүлэлтийн шинж чанартай хоёр хүчин зүйлийг дурдвал хатуу түлшний үнийг Засгийн газраас 75 хувийн хөнгөлөлт үзүүлж байгаа. Мөн цахилгаан, дулааны үнийг хөнгөвчилсөн. Нефть бүтээгдэхүүний үнэ ерөнхийдөө зохицуулалттай явж байгаа. Өнгөрсөн жилийн туршид бий болсон нефть бүтээгдэхүүний үнийн бууралтыг дотоодын бензин, шатахууны үнэд тусгасан

байгаа. Оны хоёрдугаар улирал гэхэд зохицуулалттай үнүүд өөрчлөгдөх хандлагатай байгаа. Тухайлбал, хатуу түлшний үнэ, бензин, шатахууны үнийн өөрчлөлттэй холбоотойгоор хоёр нэгж хувийн инфляц 4-5 дугаар сард бий болно. Тэгэхээр одоогийн 2 нэгж хувийн инфляцын түвшин 4-5 хувьд хүрэх төлөвтэй байгаа. Үүн дээр инфляц өсчихлөө гэж цочирдох хэрэггүй, энэ бол хүлээгдэж байгаа зүйл. Үүнийг Монголбанк тооцоо, судалгаандаа ашиглаад явж байгаа. Үүнээс цааш оны эцэст инфляц 7.2 орчим хувьд хүрэх төсөөлөлтэй байгаа. Энэхүү 7 орчим хувийн өсөлт нь 2021 оны дөрөвдүгээр улирал, 2022 оны нэгдүгээр улиралд хадгалагдах болов уу. Үүнд эдийн засаг 6.1 хувиар өсч байгаа нь нөлөөлж байгаа. Нөгөө талаас хатуу түлшний үнийн хөнгөлөлт хэвийн түвшиндөө очих учраас суурь үеийн нөлөө орж ирж байгаа. Улмаар 2022 оны хоёрдугаар улирлаас инфляц эргээд 6 хувийн түвшиндөө хүрч, буурах төсөөлөлтэй байна.

Мөнгөний бодлогын хорооны мэдэгдэлд тусгасан зүйл нь юу гэхээр инфляц төв банкны зорилтот түвшинд байх нь. Эдийн засгийн сэргэлт, хүлээлт эерэг байна. Боловсруулах салбар, уул уурхайн салбар, эрчим хүчний салбарт эерэг нөлөөллүүд гарч ирнэ. Энэ бүх нөлөөллийг төв банкны бодлогын шийдвэр гаргаж байгаа тооцоо, судалгаа харгалзан үзэж байгаа. Эдийн засгийн сэргэлт бидний хүлээж байгаагаас илүү эрчимжих, инфляци илүү ихээр өсөх тохиолдолд төв банкны хувьд бодлогын тохируулга хийх боломж нээлттэй байгаа.

Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүн Ц.МӨНХБАЯР:

Бодлогын хүү буурахад гурван хүчин зүйл нөлөөлдөг. Нэгдүгээрт, хүү бол хөрөнгийн өгөөж юм. Тиймээс бид хүлээгдэж буй буюу “бодит хүүг” хардаг. Өнөөдөр хүү 6% байхад инфляц 7%-тай байна гэвэл хүү хасах утгатай гарна. Тиймээс бодлогын хүүг цаашид бууруулах орон зай нь хүлээгдэж буй инфляцаар хязгаарлагддаг. Хоёрдугаарт, төгрөгийн өгөөжийг хадгалах шаардлагатай. Гуравдугаарт, Төв банк зөвхөн инфляц төдийгүй санхүүгийн тогтвортой байдлыг хардаг. Тиймээс санхүүгийн системийн эрүүл, тогтвортой байдлыг хангахын тулд хүүгийн түвшин чухал үүрэгтэй.

Эдийн засагт үүсэж буй одоогийн нөхцөл байдлууд нь цар тахалтай холбоотой байна. Арилжааны банкуудын зээлийн өсөлт өнгөрсөн оны хоёрдугаар улирлаас буурч байгаад одоо сэргэх төлөвт орж байна. Тэгэхээр энэхүү сэргэлтийн хурд нь цар тахлын үед авч буй арга хэмжээний үр дүн, вакцинжуулалт хэр хурдтай явагдах, цар тахлын тархалт цаашид хэр байх вэ гэдгээс ихээхэн хамаарна. Тиймээс цаашид санхүүгийн бодлого гэхээс илүүтэйгээр, захиргааны арга хэмжээ буюу экспорын үйл ажиллагаанд эрүүл ахуйг баталгаажуулж, тээвэр ложистикийн үйл ажиллагааг тогтвортой сайн явуулах, вакцинжуулалтыг энэ эрчээрээ тууштай явуулах мөн долдугаар сарын нэгнээс энгийн горимд шилжих бодлогын арга хэмжээг уян хатан, эдийн засагт үзүүлэх “шок” багатайгаар хийх хэрэгтэй.

Төсөвт орон зай байхгүй байгаа тул мөнгөний бодлого уруу түлхүү оролцоод байгаа. Тиймээс цаашид төсвийн орон зайг өөрсдөө бий болгож дараа дараагийн бэлтгэл ажлыг хангахад бодлогын орон зайтай болох нь чухал байна. Мөнгөний бодлогоос гадна Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ олон бий. Тэгэхээр эдгээр арга хэмжээ нь цаашид инфляцын төлөв, эдийн засгийн өсөлтийн хурдад нөлөөлнө. Тиймээс дараа дараагийн хурлаар эдгээр нөхцөл байдлын шинэчилсэн төсөөллийг гаргаж шийдвэрүүдээ гаргах хүлээлттэй байна. 2016 оны үеийн эдийн засгийн хүндрэлийн хувьд арван улирал орчим үргэлжлээд хаагдаж байсан бол одоогийн эдийн засгийн хүндрэлийг найман улирлын турш үргэлжлээд эргэж сэргэнэ гэж тооцоолж байгаа. Тиймээс бид эдийн засгийн төлвийг эерэгээр харж байна. Гэвч эдийн засгийн бодлогын шийдвэрүүдийг хязгаарлаж байгаа зүйл бол цар тахлын тархалт, вакцинжуулалтын хурд байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2021 оны 3 дугаар сар

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)



Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үсэс **19.6** хувиар өсч **24.6** их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн **14.6** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **3.5** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **2.4** нэгж хувийг төгрөгийн харилцах, **0.6** нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, **-1.5** нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.
- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **19.0** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **5.6** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.



2. Зээл

Зураг 2.1. Зээлийн өөрчлөлт




Зураг 2.2. Зээлийн чанар



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үсэс **1.3%-**иар буурч **17.0** их наяд төгрөг Иргэд олгосон зээлийн үлдэгдэл **1.7%-**иар буурч **8.5** их наяд төгрөгт Хувийн байгууллагынх **5.3%-**иар буурч **7.9** их наяд төгрөгт хүрэв.
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **0.5%-**иар буурсан ба 107.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл “МИК ОССК”-руу шилжив. Хугацаа хэтэрсэн зээл **3.0%-**иар өсч 1,346.6 тэрбум төгрөгт Чанаргүй зээл **0.2%-**иар өсч 2,009.9 тэрбум төгрөгт хүрэв.

2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.3. Нийт зээл, гадаад валютын зээлийн эзлэх хувь




Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



- Нийт зээл **17.0** их наяд төгрөг (төгрөгийн зээл **15.3** их наяд, гадаад валютын зээл **1.6** их наяд төгрөг)
- Нийт зээлийн **9.6%-**ийг, иргэдийн зээлийн **0.8%-**ийг, хувийн байгууллагын зээлийн **18.9%-**ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.


2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.5. Хугацаа хэтэрсэн зээл (олгосон салбараар)



Хугацаа хэтэрсэн зээлийн 77.8% нь хувийн байгууллагын зээл


Зураг 2.6. Чанаргүй зээл (олгосон салбараар)



Чанаргүй зээлийн 74.0% нь хувийн байгууллагын зээл

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр



- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн 74.2 хувь нь хотөлбөрийн зээл, 22.0 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 3.8 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Орон нутгийн ипотекийн зээл*-ийн 75.6 хувь нь хотөлбөрийн зээл, 22.2 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.2 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

*Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршилаар тооцсон.

Зураг 3.2. Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт



- Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 92.9 хувь нь хэвийн, 2.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 4.4 хувь нь чанаргүй зээл байна.
- Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 63.3 хувийг хотөлбөрийн зээл, 36.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 0.5 хувийг бусад эх үүсвэрийн зээл тус тус эзэлж байна.


3. Ипотекийн зээл /үргэлжлэл/

Зураг 3.3. Тайлант сард олгосон ипотекийн зээл



- Тайлант сард банкууд 667 эзэлдэгчид 51.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 53.2 хувь нь хотөлбөрийн, 46.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.4. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




- Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч, өмнөх сараас 1.2 нэгж хувиар өсч 10.0 хувьд хүрсэн байна.

4. ХҮҮ

Зураг 4.1. Тухайн сард шинээр татсан хадгаламж, хүү




Зураг 4.2. Тухайн сард шинээр олгосон зээл, хүү



- 2021 оны 2 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 7.1 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.3 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 15.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 9.3 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна

*Хотомборийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүгнэлтийг оруулаагүй болно.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2021 оны эхний 2 сар /урьдчилсан/



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС



"ЦАГААН АРСЛАН" одон (хуучнаар БНСЧСУ-ын)

Он: 1922

Жин: 289 грамм

Голч: 6.5 см

Таван хошуу хэлбэрийн унжлага, зүүлт бүхий хүзүүний гинж, энгэт хадах найман талт одоос бүрдэнэ. Цагаригны голд Чесослаак улсын төрийн сүлдний хос сүүлт цагаан арслангийн дүрс "ZA VITEZNEVSTVI" гэсэ славян бичигтэй. Хүзүүний гинжийг алтыг дөрвөлжин хийж, хооронд нь зөрүүлэн холбон хос эгнээтэй хийсэн байна. Гинжний төв хэсэгт цэнхэр өөнгийн эрдэнийн чулуун суурийг Грек-Ромын шударга үнэнийн шинж чанарыг харуулдаг линден хэмээх навчийг хийж, түүний дээр Чехслова улсын нэрийг товчилсон үсгүүдийг алтаар товойлгоон бичжээ. Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлнэ Ю.Цэдэнбалыг 1973онд энэхүү нэр хүндтэй одонгоор шагнасан байна.



ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НД ТУСГАГДСАН “АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛ”-Д ХАМРАГДАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ЗОРИУЛСАН

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

1. Зээлийг хаанаас авч болох вэ?

Та өөрийн харилцдаг аль ч арилжааны банканд хандаж зээл авах хүсэлтээ гаргах боломжтой. Одоогоор арилжааны банкууд хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай зээлийн материалыг бүрдүүлж, олголтыг хийж эхлээд байна.

2. Тус зээлийн нөхцөл нь юу вэ?

Нэг зээлдэгч буюу аж ахуйн нэгж, түүний хамаарал бүхий этгээдэд олгох зээлийн хэмжээ 500 сая төгрөг хүртэл, зээлийн хугацаа 3 жил хүртэл, зээлийн жилийн хүү 3 хувь, эргэн төлөлтийн график сар бүр тогтмол дүнгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй.

3. Зээлийн зориулалт юу вэ?

Зээлийн зориулалт нь Зээлдэгч ажлын байраа хадгалах, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахад шаардагдах эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэх, банкнаас ижил зориулалтаар авсан зээлийг дахин санхүүжүүлэх юм.

4. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн барьцаа хөрөнгө хангалтгүй бол Зээлийн батлан даалтын сан оролцож байгаа гэсэн. Ямар нөхцөл, шаардлага хангасан хуулийн этгээд хамрагдах вэ?

Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4.1.1-д заасан буюу 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн барьцаа хөрөнгийн

дутагдалтай хэсэг (үндсэн зээлийн 60 хүртэл хувь буюу 300 сая төгрөг хүртэл)-т батлан даалт гаргана.

5. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн тодорхойлолт хаанаас авах вэ? Банканд өгөх шаардлага байгаа юу?

Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4.1.1-д заасан буюу 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой байх шаардлагыг хангасан бол заавал тодорхойлолт шаардахгүй.

6. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч биш бол 3 хувийн хүүтэй зээлд хамрагдаж болохгүй гэсэн үг үү?

Зээлийн батлан даалтын санд хамрагдаагүй зээлдэгчийн хувьд салбар харгалзахгүй олгох боломжтой. Өөрөөр хэлбэл тухайн зээлдэгч буюу аж ахуйн нэгж банкны барьцаа хөрөнгийн шаардлага болон бусад зээлийн шаардлагыг хангасан бол зээлд хамрагдах боломжтой.

7. Зээлийг эхний хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөх үү?

Таны зээлийн эргэн төлөлтийн нийт төлбөр сар бүр тогтмол дүнгээр төлөгдөх бөгөөд 12 сар эсвэл зээлийн нийт хугацааны гуравны нэгээс хэтрэхгүй хугацаагаар үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх боломжтой. Та банктайгаа харилцан ярилцаж, зээлийн эргэн төлөлтийн графикт энэ талаар тусгуулах боломжтой.



8. Ажлын байрыг дэмжих зээл хэдий хугацаанд үргэлжлэх вэ?

Тус зээлийн хувьд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд арилжааны банкуудаар дамжуулан олгогдохоор байна.

9. Хамаарал бүхий этгээд гэдгийг юу гэж ойлгох вэ?

“Хамаарал бүхий этгээд” гэж тухайн аж ахуйн нэгжийн хувьцааны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

10. Зээлдэгчид тавигдах шаардлага нь юу байгаа вэ?

- а) Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн байх;
- б) Банкнаас зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд энэ гэрээг хэрэгжүүлэхтэй нийцэж тавигдсан бусад шаардлага.
- с) Энэ заалтын а-д заасан шаардлагыг хангаж

байгаа эсэхийг Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын лавлагаагаар тодорхойлно.

11. Өмнө нь Зээлийн батлан даалтын сангаар зээл авсан байгаа. Энэ зээлээ дахин санхүүжүүлэх хэлбэрээр зээл авч болох уу?

Болно. Дахин санхүүжилтийн зээлд хамрагдаж болно. Гэхдээ таны энэ зээл Зээлийн батлан даалтын санд хамрагдах боломжгүй. Учир нь Зээлийн батлан даалтын сангийн 3 хувийн зээлд гаргаж буй батлан даалт зөвхөн шинээр олгож буй зээлүүдэд хамаарч байна.

12. Зээлийн 3 хувийн хүүг ямар нөхцөлд цуцлах вэ?

Зээлдэгч зээлийн төлбөр (зээлийн үндсэн төлбөр, эсвэл хүүгийн төлбөр)-ийг 90 болон түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, бусдад дамжуулан зээлдүүлсэн, зориулалтын бусаар ашигласан бол зээлийн хүүгийн дэмжлэгийг цуцалж, хүүгийн дэмжлэггүй бизнесийн зээлд шилжүүлэхийг анхааруулж байна.

13. Хоршоо болон нөхөрлөл зээлд хамрагдаж болох эсэх?

Нөхөрлөл нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд тул зээлийн шаардлагад заасан “зээлдэгч”-д хамаарна. Хоршоо нь Хоршооны тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд тодорхойлсноор үйлдвэрлэл, үйлчилгээ, бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагаа буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, ажил олгогч хоршоо энэ зээлд хамрагдах боломжтой.

14. Төрийн бус байгууллагад зээлд хамрагдаж болох эсэх?

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд зааснаар батлан даалттай зээлийг төрийн бус байгууллагад олгож болохгүй. Мөн Төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус буюу бизнес-аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй тул хамрагдахгүй.

ВИРТУАЛ ХӨРӨНГӨ ГЭЖ ЮУ ВЭ?

Технологийн дэвшлийн үр нөлөөгөөр олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр бий болж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байна. Эдгээрийн нэг нь тархмал бүртгэлийн технологид суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээ юм. Виртуал хөрөнгөд биткойн, этериум зэрэг крипто валютуудаас гадна төрөл бүрийн токениуд багтдаг.

Виртуал хөрөнгө, крипто валютыг олон улсын байгууллагууд янз бүрээр тодорхойлсон байдаг. Тухайлбал, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-аас гаргасан тодорхойлолтыг илүү түгээмэл ашигладаг бөгөөд виртуал хөрөнгө нь дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор

ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл гэж тодорхойлсон.[1] Харин Европын Төв Банк виртуал валютыг зохицуулалтгүй дижитал мөнгөний шинжийг агуулсан, хөгжүүлэгч этгээдийн хяналтад байдаг, тодорхой бүлэг хүмүүсийн дунд хүлээн зөвшөөрөгдөж хэрэглэгддэг хэрэгсэл гэж үзсэн байна.[2] Мөн Европын Банкны Зохицуулагч Байгууллагаас виртуал валютыг цаасан мөнгөтэй хамааралгүй, Төв банк болон аливаа төрийн эрх бүхий байгууллагаас гаргаагүй боловч төлбөр тооцоонд хэрэглэж, цахим байдлаар шилжүүлж, хадгалж, арилжаалах боломжтой хэрэгсэл гэж тодорхойлжээ.[3]

Виртуал валют болон цаасан мөнгөний ялгаа

	Виртуал валют	Цаасан мөнгө
Хууль эрх зүйн байдал	Эрх бүхий байгууллагаас хяналт тавьдаггүй	Төв банкнаас гаргаж, зохицуулалт хийдэг
Үнийн өөрчлөлт	Эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн үнэ хэлбэлздэг	Эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгддөг
Биет байдал	Цахим орчинд оршдог, биет бус шинж чанартай	Цаасан эсхүл зоосон биет болон биет бус хэлбэртэй
Нийлүүлэлт	Анх гаргахдаа нийт хэмжээг тогтоодог	Төв банкнаас мөнгө хэвлэх тоо хэмжээнд хязгаар тогтоодоггүй
Хадгалалт	Цахим орчинд крипто хэтэвчид хадгалдаг	Биет болон дижитал хэлбэрээр хадгалах боломжтой
Гүйлгээний бүртгэл мэдээлэл	Олон нийтэд нээлттэй, тархмал бүртгэлийн технологи дээр үндэслэнэ	Банк санхүүгийн байгууллагын төвлөрсөн системийг ашиглан бүртгэнэ


КРИПТО ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын байдлаар 4000 гаруй нэр төрлийн крипто валют цахим орчинд

бий болсон [4] бөгөөд эдгээрээс хамгийн их эрэлттэй 5 крипто валютын үнэлгээ, зах зээлийн хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар дараах хүснэгтэд харуулав. Үүнд:[5]

Д/д	Нэр	Үнэ	Зах зээлийн хэмжээ	Нийлүүлэлтийн хэмжээ
1	Биткойн	\$ 57,965.83	\$ 1,082.1 тэрбум	18.7 BTC
2	Этериум	\$ 1,771.79	\$ 204.2 тэрбум	115.2 ETH
3	Бинанс	\$ 273.33	\$ 42.2 тэрбум	154.5 BNB
4	Тетер	\$ 1.00	\$ 40.5 тэрбум	40,477.5 USDT
5	Кардано	\$ 1.21	\$ 38.6 тэрбум	31,948.3 ADA

Зах зээлийн бүтэц[6]



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан (ОУВС)

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ


Өнгөрсөн жилүүдэд хэд хэдэн крипто арилжааны платформ болон крипто хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчид цахим халдлагад өртөж, харилцагчдын койн, токenuуд алдагдсан хэргүүд гарсан байна. Иймээс виртуал хөрөнгийн зах зээлд хангалттай аюулгүй тогтолцоо хараахан бүрдээгүй байгаатай холбоотойгоор

хэрэглэгчид цахим халдлагад өртөж, хохирол амсах эрсдэлтэй юм.


Крипто валютад тодорхой үнэ цэнэ байхгүй бөгөөд зохицуулагч байгууллагуудын хяналтад хамаардаггүй тул үнийн хувьд ихээхэн хэлбэлзэлтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор крипто арилжааны үйлчилгээ үзүүлэгчид болон харилцагчид зах зээлийн эрсдэлд ордог. Мөн

криптокойн гаргагчийн дефолт болон зээлийн эрсдэл нь тухайн койны үнэд нөлөөлөх боломжтой. Түүнчлэн койн гаргагч болон арилжаалагчид хоорондоо хуйвалдах, ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай байдаг байна. Харин хөрвөх чадварын эрсдэл нь харилцагчид болон хөрөнгө оруулагчид койныг бусад валют, хөрөнгөд хөрвүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээ авахтай холбоотой үүсдэг.

Доорх графикаас харахад уламжлалт санхүүгийн зах зээл дэх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн хэлбэлзэл 20 хувиас илүүгүй байхад Биткойны үнэ ойролцоогоор 190 хувь хүртэл хэлбэлзсэн байгаа нь илүү өндөр эрсдэлтэй болохыг илтгэж байна.




Тухайлбал, Биткойны үнэ нь 2017 оны 4 дүгээр улиралд 2 мянган ам.доллараас 20 мянган ам.доллар болж огцом өссөн бөгөөд улмаар 2018 оны 1 дүгээр улиралд буюу хэдхэн сарын хугацаанд эргээд 3 мянган ам.доллар болж буурсан байдаг. Иймд энэхүү үнийн савалгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчид ихээхэн эрсдэлтэй нүүрлэж байжээ.



ГЭМТ ХЭРЭГ

Крипто валютын зах зээлийн талаар судалгаа хийдэг олон улсын Чэйналисис компанийн мэдээлснээр тус зах зээлд 2018 онд нийт 5 тэрбум ам.доллартой дүйцэхүйц хэмжээний хууль бус койн эргэлдэж байсан бол 2019 онд 20 тэрбум ам.доллар хүрч нэмэгджээ. [7] Харин 2020 онд гэмт хэргийн шинж чанартай койны эргэлтийн хэмжээ 10 тэрбум ам.доллар болж буурсныг дэлхийн улс орнууд хяналт зохицуулалтын орчинг бүрдүүлж эхэлсэн, Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр эдийн засаг агшсан болон крипто арилжааны үйлчилгээ үзүүлэгчид мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулсантай холбоотой гэж үздэг. Крипто валюттай холбоотой 2020 онд гарсан гэмт хэргүүдийг авч үзвэл 67% нь луйвар, 18.4% нь хар зах дээр хийсэн гүйлгээ, хар тамхины наймаа, 9.6% нь цахим халдлага байсан бол 0.1% нь терроризмыг санхүүжүүлэх, айлган сүрдүүлэх гэмт хэрэг тус тус эзэлсэн байна. [8] Цаашид крипто валютын технологид суурилсан шинж чанар, арилжаанд оролцохдоо нэр, хаягаа нууцлах боломж, хяналт зохицуулалтад хамаардаггүй байдлыг гэмт этгээдүүд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглах хандлагатай байна.



ЗОХИЦУУЛАЛТ

Крипто валютын зах зээл шинээр хөгжиж байгаа боловч ирээдүйн чиг хандлага нь тодорхойгүй байгаагаар холбоотойгоор дэлхийн улс орнууд уг зах зээлийг зохицуулах эсхүл хориглох тал дээр ялгаатай байр суурийг баримталж байна.

Монгол Улсын хувьд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”-ийн төслийг боловсруулсныг УИХ-д өргөн барьсан бөгөөд хууль батлагдсанаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Эх сурвалж

1. Fatf - gafi. guidance for a risk-based approach. www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/RBA-VA-VASPs.pdf. Accessed 29 Mar. 2021
2. Virtual currency schemes, October 2012 - European Central Bank. www.ecb.europa.eu/pub/pdf/other/virtualcurrencyschemes201210en.pdf. Accessed 29 Mar. 2021
3. “Report on Virtual Currencies.” Europarl. europa.eu, www.europarl.europa.eu/doceo/document/A-8-2016-0168_EN.html. Accessed 29 Mar. 2021
4. Conway, Luke. “The 10 Most Important Cryptocurrencies Other Than Bitcoin.” Investopedia, Investopedia, 4 Mar. 2021, www.investopedia.com/tech/most-important-cryptocurrencies-other-than-bitcoin/#:~:text=One%20reason%20for%20this%20is,communities%20of%20backers%20and%20investors.
5. “Blockchain.com Explorer: BTC: ETH: BCH.” Blockchain Explorer - Search the Blockchain | BTC | ETH | BCH, www.blockchain.com/explorer, Accessed 29 Mar. 2021
6. Cristina Cuervo, Anastasiia Morozova. “Regulation of Crypto Assets.” IMF, www.imf.org/en/Publications/fintech-notes/Issues/2020/01/09/Regulation-of-Crypto-Assets-48810.
7. Chainalysis. “Crypto Crime Summarized.” Chainalysis, 2021, blog.chainalysis.com/reports/2021-crypto-crime-report-intro-ransomware-scams-darknet-markets.
8. Crawley, Jamie. “Crypto Crime Siphoned Off Nearly \$10.5B in 2020: Research.” CoinDesk, CoinDesk, 1 Mar. 2021, www.coindesk.com/crypto-crime-siphoned-off-nearly-10-5b-in-2020-research. Accessed 29 Mar. 2021

САНСАР-40 ЖИЛ

Дүрсгалын зоос



"Сансар-40 жил" зоос нь сансрын уудам байдлыг "obsidian black" технологи ашиглан хар өнгөөр харуулж, сар болон дэлхийг өнгөтөөр дүрсэлсэн. Мөн "Союз-39" хөлгөөр "Салют-6" сансрын станцтай холбогдсон байгаагаар дүрсэлж, БНМАУ-ЗХУ-ын сансрын хамтарсан нислэгийн Монгол талын логог дүрсэлжээ. Түүнчлэн Монгол Улсын говь, цөл нутагт Марс гаригтай хамгийн төстэй орчин, нөхцөл бүрдүүлэн, туршилт, хөгжүүлэлтийн бааз байгуулан, хүний нөөц чадварыг хөгжүүлэхээр ажиллаж буй "MARS-V" төслийг таниулан сурталчлах үүднээс дэлхийн бөмбөрцөг дээр тус төслийн логог дүрсэлжээ.

ТӨВ БАНКУУДЫН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

2021 оны 1 дүгээр улирал



АНУ-ын Холбооны Нөөцийн Банк /2021.3.17/

- Бодлогын хүүг **0-0.25%**-д хэвээр үлдээв
 - Актив худалдан авалт: Сард **120 тэрбум** ам.долларын санхүүжилт
- "Холбооны нээлттэй зах зээлийн хороо инфляц тогтвортой зорилтот түвшинд хүрэх хүртэл мөнгөний бодлогыг зөөлөн төлөвт хадгална"*



Английн Төв банк /2021.3.18/

- Бодлогын хүүг **0,1%**-д хэвээр үлдээв
 - Актив худалдан авалт: **895 тэрбум** фунт стерлингийн санхүүжилт
- "Зөвлөл тогтвортой инфляц зорилтот 2%-д хүрч, эдийн засгийн илүүдэл нөөц буурах хүртэл мөнгөний бодлогыг чангаруулах арга хэмжээ авахгүй"*



BANK OF JAPAN

Японы Төв банк /2021.3.19/

- Өгөөжийн муруйн удирдлага/YCC/:
 - Богино хугацааны хүүг **-0,1%**-д хэвээр үлдээв
 - 10 жилийн хугацаатай Японы Засгийн Газрын бонд /JGB/-ын өгөөжийг **0%**-д хадгалахын тулд JGB-г шаардлагатай хэмжээгээр худалдан авна
- Актив худалдан авалт: ETFs болон J-REITs нийт **180 тэрбум** иен

"Инфляцын зорилтоо тогтвортой түвшинд хүргэхийн тулд өгөөжийн муруйг удирдах мөнгөний зөөлөн бодлогыг үргэлжлүүлсэн хэвээр байна"



Европын Төв банк /2021.3.11/

- Бодлогын хүүг **0.00%(MRO), 0.25% (MLF), -0.50%(DF)**-д хэвээр үлдээв
- Актив худалдан авалт: APP хөтөлбөрт сард **20 тэрбум** евро
- Цар тахлын онц байдлын хөтөлбөр /PEPP/-ийн хүрээнд **1850 тэрбум** еврогийн санхүүжилтийг 2022 оны 3 дугаар сар хүртэл үргэлжлүүлнэ

"Инфляцыг зорилтот түвшинд хүргэхийн тулд мөнгөний бодлогын бүхий л боломжит арга хэмжээг авахад бэлэн байна"

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО: БУСАД ОРНЫ ТУРШЛАГААС СУРАЛЦАХУЙ

Доожавын ГАН-ОЧИР¹

Монгол Улсын хууль тогтоомжид эдийн засгийн бодлого, зохицуулалт, төлөвлөлтийн талаар тодорхой заалтууд орж, мөрдөгдөж байна. Тухайлбал, Үндсэн хуульд Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байхыг тунхагласан. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулж байхаар тусгасан. Байгалийн баялагийг ашиглах, орлогын дахин хуваарилалтыг хийх төрийн зохицуулалт, зарчмын хувьд 'байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.' гэж онцолсон. Сүүлийн 30 жилийн сургамж дээрээ үндэслэн Монгол Улс хөгжлийн алсын хараагаа гаргаж, түүнд хүрэхэд бүх талуудын зөвшилцөл байх ёстой гэсэн зарчим гаргаж, энэ хүрээнд 'Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна' гэсэн заалтыг 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр нэмж тусгасан. Үндсэн хуулийн өөрчлөлттэй нийцүүлэн 2020 оны 5 дугаар сард баталсан 'Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай' хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх,

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох зэрэг тодорхой зохицуулалтууд тусгаад байна.

Гэхдээ бодит байдал, институцийн хувьд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн оновчтой нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төлөвлөх үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцаа бүрэн тодорхой болоогүй, хөгжлийн зорилт, хэрэгжилтийг хангахад төрийн бодлогуудын харилцан уялдаа тодорхой бус хэвээр байна. Ялангуяа, Монгол төрийн эдийн засгийг төрөлжүүлэх, гадаад худалдаа, аж үйлдвэрийн бодлого, салбар дундын бодлого бараг 'эзэнгүй' явж байна. Манай улсад хөгжлийн процесст шаардлагатай элемент, агентлагууд дан дангаараа байгаа боловч, тэднийг зангидан нэгтгэсэн тогтолцоо бүрдүүлж, бүрэн ажиллагаатай нэгдсэн механизм болгож ажиллуулах байдал дутагдалтай байна.

Иймд энэхүү судалгааны өгүүлэлээр Зүүн Азийн хөгжлийн загварын гол төлөөллүүд болсон Япон, Солонгос улсын хөгжлийн болон аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог судалж, түүн дээр үндсэн өөрийн оронд авч хэрэгжүүлж болох сургамж, туршлагыг тоймлохыг оролдов. Тэр дундаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төлөвлөх үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг тодорхой болгох чиглэлд санал гаргахыг зорив.

Монгол Улсын хөгжлийн шинэ загвар нь төрөлжсөн эдийн засгийг бий болгох, чиг баримжаа нь 'хүн төвтэй' буюу амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэх нь зүйтэй. Хөгжлийн стратеги, зарчим бол байгалийн баялгийг эдийн засгийн хөгжилд шилжүүлэх (уул уурхайн эдийн

¹ Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор (PhD), Дэд профессор. Энэхүү судалгааны өгүүлэлийн дэлгэрэнгүйг Монголбанкны Судалгааны ажлын товхимол 15 (<<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group15/01.pdf>>)-аас унших боломжтой.

засгаас мэдлэг шингээсэн олон тулгууртай эдийн засаг руу шилжих), тэр дундаа Монгол хүний хөгжил, оюун ухааныг хөгжүүлж, нэмүү өртөг шингээсэн, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох явдал юм. Төрөлжсөн эдийн засгийг бий болгох нь нөөц хөрөнгийн төрөлжилт (институцийг бэхжүүлэх, хүний хөгжил, чадавхыг бий болгох, оюундаа хөрөнгө оруулалт хийх) болон бүтээгдэхүүний төрөлжилтийг бүрдүүлэх явдал юм. Бүтээгдэхүүний төрөлжилт нь экспортод чиглэсэн, ГШХО-ын төрөлжилтийг далласан хэлбэртэй байх ёстой болно. Энэ төрөлжилтийг амжилттай хийхийн тулд аж үйлдвэрийн бодлого, гадаад худалдааны бодлого, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн бодлого нь харицлан нягт уялдаатай байх ёстой. Түүнчлэн экспортод чиглэсэн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх урьдач нөхцөл нь 1) хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тодорхой туссан байх, 2) экспортыг дэмжих асуудлыг хариуцсан тусгай нэгж, хэрэгсэл байх, 3) экспортын санхүүжилтийн схем тодорхой байх зэргийг шаарддаг.

Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай салбар, бүтээгдэхүүн л глобал өрсөлдөөнд 'амьд' үлдэнэ. Иймд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого нь аж үйлдвэрийн бодлоготой бүрэн нийцтэй, түүнийг дэмжсэн байх учиртай. Аж үйлдвэрийн салбар хөгжиж байж 'хэрэглэгч, импортлогч' орноос 'үйлдвэрлэгч, экспортлогч' орон болж, урсгал тэнцлийн алдагдал буурч, 'гадаад өр'-өө нэмэгдүүлэх бус, бууруулах юм.

Энэ үүднээс эдийн засгийн, хөгжлийн төлөвлөлтийн тогтолцооны хувьд дараах саналыг дэвшүүлж байна:

- Төлөвлөвлөлтийн процесс нь: Ерөнхий сайд <= Үндэсний хөгжлийн зөвлөл (түүний дэргэдэх дэд зөвлөлүүд) <= үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (шинээр байгуулах) <= гадаад худалдаа, аж үйлдвэрийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (шинээр байгуулах) болон бусад яам, агентлагууд <= Яам, агентлаг дээрх зөвлөлүүд гэсэн ерөнхий бүдүүвч байх боломжтой. Үүнийг дараах хэсэгт задлан авч үзье.
- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн сайд (эсвэл Ерөнхий сайд ахлаад, тус сайд орлогчоор ажиллаж болно) -аар ахлуулсан Үндэсний

хөгжлийн (эсвэл Үндэсний эдийн засгийн) зөвлөл байх, зөвлөлийн гишүүд нь бизнес, эдийн засгийн болон бусад салбарын лидерүүд, төрд ажиллаж байсан (улс төрийн болон мэргэжлийн капиталтай) албан тушаалтнууд байх. Тус зөвлөл нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар Ерөнхий сайдад зөвлөх үүрэг гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд дэд зөвлөлүүд байгуулан ажиллуулах.

- Эдийн засгийн зөвлөлийн нарийн бичгийн үүргийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (Японы Эдийн засгийн төлөвлөлтийн агентлагтай адил, шинээр байгуулах) хариуцана. Тус яамны бүтцийг 1970-аад оны Японы Эдийн засгийн төлөвлөлтийн агентлагтай бүтцийг харгалзан, өөрийн орны онцлог (одоогийн ҮХГ-ын бүтэц, ноу-хау)-ийг тусгасан байдлаар хийж болно. Тус яам нь баримт бичгийн нэгтгэл, эцсийн боловсруулалт (бусад яамд болон агентлагуудын мэргэжилтнүүдийг зөвлөмж, тусламжийг авч боловсруулна)-ыг хийж, Үндэсний хөгжлийн зөвлөлд өргөн барина.
- Төлөвлөлтийн процесс шуурхай, үр дүнтэй хийгдэхэд түүнийг гардан хариуцах яам, түүний сайдын эрх мэдэл хүчтэй байх шаардлагатайг бусад орны туршлага харуулдаг. Иймд энэ хүчин зүйлийг харгалзах нь зүйтэй.
- Түүнчлэн гадаад худалдаа, аж үйлдвэрийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулах (Японы MITI-тэй адил, шинээр байгуулах) онцгой шаардлагатай байна. Ийнхүү аж үйлдвэржилтийн бодлого, худалдааны бодлого, төлөвлөлтийг 'хариуцсан эзэн'-тэй болгож, экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийг системтэй хөгжүүлэх хэрэгцээ өндөр байна. Тус яам нь хариуцсан салбар бүрийн зорилтыг хянах, салбар дундын уялдааг хангаж ажиллах, тухайн зорилтыг хангахын тулд шаардлагатай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байна. Тус яамны сайдын дэргэд мөн Аж үйлдвэр, худалдааны зөвлөл ажиллана.
- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан яам (эсвэл худалдаа, аж үйлдвэрийн яам)-ны дэргэд Хөгжлийн судалгааны хүрээлэн (Солонгосын KDI, Японы ERI эсвэл RIETI-тэй адил адил) байгуулж

ажиллуулах. Тус хүрээлэн нь бодлого, салбарууд дахь реформын санал боловсруулах, холбогдох судалгаа хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэхүү судалгааны хүрээлэн нь төлөвлөлт, хэрэгжилтийн процессыг дангаар шууд хариуцахаас илүүтэй бодлого, зөвлөмж, санал боловсруулах чиг үүрэг гүйцэтгэнэ.

- Салбар яам бүр дээр бодлого, төлөвлөлт хариуцсан нэгжүүд (Японы Genkyoku-тэй адил)-ийг тодорхой болгож, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн процесс дахь чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай.

Хэрэв эдгээр хоёр яам (Гадаад худалдаа, аж үйлдвэрийн болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд)-ыг нэгэн зэрэг байгуулах нь санхүүгийн чадавх, улс төрийн орчны хувьд боломжгүй тохиолдолд Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан яамны чиг үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх, газар (ЗГХЭГ)-т шилжүүлж, тус газарт хөгжлийн төлөвлөлт хариуцсан тусгай газар шинээр байгуулж ажиллуулж болох юм. Харин аж үйлдвэрийн салбаруудын нэгдсэн бодлого, салбар дундын бодлого, уялдааг хангах, төлөвлөлт хийх, гадаад худалдааны хилийн наана болон цаана байгаа саад тодгорыг арилгах, нийлүүлэлтийн, өртгийн сүлжээг бүхэлд нь хариуцан бодлого, хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэгтэй Гадаад худалдаа, аж үйлдвэрийн яамыг эн тэргүүнд байгуулах нь зүйтэй гэж харж байна.


Ийнхүү худалдаа, аж үйлдвэрийн бодлого, хэрэгжилтийн асуудал эрхэлсэн яамтай болсноор 'жинхэнэ' утгаар нь эдийн засгийн төрөлжилтийг бий болгоход чиглэсэн худалдаа, аж үйлдвэрийн бодлого хэрэгжүүлэх, тухайлбал, шинэ аж үйлдвэрийн салбарыг бий болгох, аж үйлдвэрийн салбарыг шинэчлэх, хөрөнгө оруулалтад хяналт, зохицуулалт хийх, аж үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлж босгож ирэх зэрэг арга хэмжээг авах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Эдгээр бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгслийн хувьд тариф, квот тавих, татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй санхүүжилтийн талаарх санал боловсруулж, төрийн бусад байгууллагуудтай хамтран шийдвэрлэх эрх мэдэлтэй байх ёстой болно. Өөрөөр хэлбэл, энэ яам дээр худалдаа, аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлт зангидагдаж, түүнийг хэрэгжүүлэх эцсийн саналууд гарч ирнэ.

Бусад орны туршлагаас харахад төр-хувийн хэвшлийн түншлэл, тэр дундаа 'зөвшилцөлд хүрэх' арга барил нь хөгжлийн процесст чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Хөгжлийн, эдийн засгийн бодлого, төлөвлөлтөд төрийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаанаас гадна худалдаа, аж үйлдвэрийн танхим, салбарын холбоод, яамдын дэргэдэх зөвлөлүүд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Иймд манай орны хувьд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоог шийдвэр гаргах, зөвлөмж гаргах бүх түвшинд, бүх салбарт бүрдүүлэх нь чухал байна. Үүний тулд:

- Дээр дурдсан Үндэсний хөгжлийн зөвлөлд хувийн хэвшлийн төлөөллүүд (бизнесийн төлөөллийн байгууллагын удирдлага, бизнесийн салбарын лидерүүд)-ийг оруулах.
- Худалдаа, аж үйлдвэрийн болон бусад салбарын сайд нарын дэргэдэх зөвлөлүүд, дэд салбаруудын түвшин дэх дэд зөвлөлүүд байгуулж, бүх түвшинд салбарын холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулж хамтран ажиллах.
- Эдгээр зөвлөлүүд нь эцсийн шийдвэр гаргахаас илүүтэй салбарыг хөгжүүлэх 'мэргэшлийн, бодит нөхцөл байдал'-ын санал санаачилга гаргах, аж үйлдвэржилтийн бодлого, арга хэмжээнд санал өгч хамтран ажиллах чиг үүрэгтэй байна.
- Зарим тохиолдолд төрөөс баримталж буй аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд үзүүлж буй дэмжлэгийн хариуд тухайн салбар дээр ямар шинэчлэл, өөрчлөлт хийгдэх шаардлагатай талаар зөвшилцөл, тохиролцоонд хүрэх асуудал ч яригдах ёстой болно.
- Японы 'зөвшилцөл' арга, барил нь төр-хувийн хэвшлийн лидерүүд 'хэт' ойр, хамтарч ажиллаж байна гэсэн хардлага, шүүмжлэлийг дагуулдаг байсан тул зөвлөл, шийдвэр гаргалтын процесс дэх хяналтын механизмыг бүрдүүлэх (жишээ нь, Японы кейс дээрх Шударга худалдааны комиссийн чиг үүргийг оруулж ирэх) шаардлагатай.

Салбар, түвшин бүр дээр төр-хувийн хэвшлийн төлөөллүүд тогтмол давтамжтай уулзаж, мэдээлэл, санал солилцох нь салбарын асуудлууд, шийдэл дээр 'хоёр талаас дөхөлт' хийгдэж, нэгдсэн ойлголттой болох, төрийн шийдвэр 'байнаас хол тусахгүй' байхад тустай юм.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 26/II ӨДРИЙН БАЙДЛААР)





МАРКУС ЛОХ: САЙН ЭДИЙН ЗАСГИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ЧУХАЛ

Бидэнэ удаагийн дугаартаа ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь суурин төлөөлөгч Маркус Лохтой бүх нийтийн санхүүгийн боловсролын тухай ярилцлаа.

АЖЛЫН ТУРШЛАГА

31 жил банкны салбарт ажилласан. Үүнээс: 15 жил хувийн болон хоршооллын банкны салбарт, 16 жил Шпаркассэ санхүүгийн нэгдэлд

- Байгууллага хөгжүүлэлт, байгууллагын удирдлага, банкны менежмент, үл хөдлөх хөрөнгийн санхүүжилт, маркетинг, борлуулалтын чиглэлээр 25 жил сургалт/көучинг хийсэн туршлагатай.
- Сертификаттай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон сургалтад хамрагдсан.
- Шпаркассэ банкны санд ажиллахын өмнө 7 жилийн турш Германы Шпаркассэ санхүүгийн нэгдэлд харьяалагддаг хөрөнгө оруулалтын байгууллагад ажиллаж байсан.
- Банкны бизнесээс гадна өөрийн сонирхлын дагуу Германы мэргэжлийн сагсан бөмбөгийн багуудын менежментийн хэсэгт ажиллаж байсан.

ХБНГУ ҮН ШПАРКАССЭ БАНК НЬ ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД ИЛҮҮТЭЙ АНХААРСАН ЗОРИЛТОД ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДЫГ ХИЙДЭГ. ЧУХАМ ЯАГААД ҮҮНД АНХААРДАГ ТУХАЙ ЮУНЫ ӨМНӨ СОНИРХУУЛНА УУ?

ХБНГУ-ын Шпаркассэ банкны олон улсын хамтын ажиллагааны сан нь 25 гаруй жилийн турш дэлхийн 50 оронд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Аливаа улс орны эдийн засаг сайн байхад банкны салбарын хөгжлөөс гадна иргэдийнх нь санхүүгийн боловсрол чухал нөлөөтэй. Бидний олон арван жилийн туршлага үүнийг маш тодорхой харуулж байна. Иймд хүн амын сайн сайхны төлөө хүн амд тохирсон сургалт, тэдгээр сургалтыг заах орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх нь бидэнд чухал юм.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ЯАГААД ЧУХАЛ БОЛОХ ТАЛААР ЦААШ ЯРИАГАА ҮРГЭЛЖЛҮҮЛБЭ. ТА ЕР НЬ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ГЭДЭГ ҮГНИЙ ТАЛААР БОДОЖ БОДОЖ ҮЗСЭН ҮҮ? ОЛОН НИЙТЭД ЭНЭ ҮГ ЮУН ТҮРҮҮНД САЛБАРЫН НЭР ШИГ БУУДАГ.

Санхүүгийн боловсрол нь санхүүгийн мэдлэг гэгддэг.

Энэ нь санхүүгийн сайн шийдвэр гаргах чадвар юм. Сайн шийдвэр нь тухайн хүний санхүүгийн сайн сайхан байдалд хүрэх амжилт байх ёстой гэсэн үг юм. Энгийнээр бол би ингэж л ойлгодог.

**МӨНГӨӨ ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛЖ СУРАХ
НЬ ХҮНИЙ Л ӨӨРИЙХ НЬ УХААН ДАДЛААС
ХАМААРАХ ЗҮЙЛ МЭТ ОЙЛГОГДОХООР
БАЙХАД ЯАГААД ЗААВАЛ БОЛОВСРОЛ ГЭЖ
АВЧ ҮЗДЭГ ГЭЖ ТА БОДОЖ БАЙНА?**

Бидний хэн нь ч бай эхээс төрөхдөө санхүүгийн боловсролтой төрчихөөгүй. Үүгээр юу хэлэхийг хүсэв гэвэл, “Хүн бүр уншиж, бичиж, тооцоолон бодож чадаж байгаа юм чинь санхүүгийн үндсэн мэдлэг, боловсролыг ч мөн адил эзэмших боломжтой гэж би бодож байна. Үүнд мэргэжилтнүүдийн дэмжлэг туслалцаа, сургалт ихээхэн хэрэгтэй. Гэхдээ үнэхээр хүссэн, сонирхсон хэн ч сурах боломжтой юм. Улаанбаатарт ч байна уу, орон нутагт ч байна уу ер нь байгаа газраас үл хамааран хүн бүр олдож буй давуу тал, боломжоо алдалгүй ашиглаарай гэж уриалах байна. Миний бодлоор санхүүгийн суурь боловсролыг уншиж, бичиж, бодож сурахтай адил анхан шатны мэдлэг болгож эзэмшүүлээсэй гэж боддог.

**ХҮН АЛЬ НАСАНДАА САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛД СУРАЛЦАЖ ЭХЛЭХ ХЭРЭГТЭЙ
ГЭЖ ҮЗДЭГ ВЭ?**

Аль болох эртхэн буюу багаасаа, оройтлоо л гэхэд сургуульд орсон үеэсээ. Санхүүгийн боловсролд суралцах хамгийн зөв бөгөөд анхны алхам арга бол Монгол Улсад жил бүрийн 10-р сард зохион байгуулагддаг “Дэлхийн хуримтлалын өдөр”-т оролцох явдал юм. Мөн Боловсролын Яамны зүгээс санхүүгийн боловсролыг сургалтын хөтөлбөрт гол хичээл болгон оруулах нь зөв болов уу. Германы Шпаркасс банкны сангийг зүгээс энэхүү шинэ хөтөлбөрийг заахад нь багш нарт дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулах, мэдээж багш, сурагчдад зориулсан сургалтын гарын авлагаар хангах боломжтой.

**ХӨГЖИНГҮЙ ОРНУУДЫН ТУРШЛАГААС ТА
ХУВААЛЦААЧ. ТУХАЙЛБАЛ ТАНЫ ЭХ ОРОН
GERMAN УЛС САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ
ТӨРИЙН ЯМАР БОДЛОГОТОЙГООР ДЭМЖДЭГ**

**ВЭ? ГАНЦ ТӨР ГЭЛТГҮЙ ГЭР БҮЛИЙН ХҮРЭЭНД
Ч ЯЛГААГҮЙ.**

Санхүүгийн боловсролын талаарх анхан шатны мэдээллийг ихэвчлэн эхлээд эцэг эхээс авдаг. Мэдээж эцэг эх нь өөрсдөө хэмнэж, санхүүгийн анхан шатны боловсролтой бол шүү дээ. Ер нь гэр бүл бүр харилцан адилгүй байдаг л даа. Харамсалтай нь Монголд ч тэр, Германд ч тэр санхүүгийн суурь боловсрол нь бүх сургуульд заавал судлах хичээл байхаар тусгагдаагүй юм. Энэ асуудал дээр Герман, Монгол аль, аль нь хөгжих хэрэгтэй байна гэж би хувьдаа үзэж байна. Санхүүгийн суурь боловсрол гэхээр банкны сурталчилгаа хийж байна гэж бодох ёсгүй юм. Нөгөөтэйгүүр, санхүүгийн мэдлэг, мэдээлэл сайтай хүмүүс, харилцагчид банктэй илүү сайн ойлголцож чадна. Ингэснээр бүх талуудад буюу харилцагчид, банканд, эдийн засагт буюу улс оронд хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, аль ч талдаа ашигтай байдал бий болно гэсэн үг.

**GERMAN ХҮН ХАМГИЙН САЙН
ХУРИМТЛУУЛАГЧ БАЙДАГ ГЭДЭГ. ЯАЖ
ҮНДЭСТНЭЭРЭА ИЙМ СОЁЛД ТӨЛӨВШИВ?**

Герман улсын хуримтлалын соёл уламжлал нь 200 гаруй жилийн түүхтэй. Анхны Шпаркасс банк нь 1749 онд байгуулагдсан бөгөөд анхны хадгаламжийн дэвтэр нь 1818 онд бий болж, өнөөг хүртэл хадгаламжийн дэвтэр гэж нэрлэгдсээр ирсэн. Мэдээжийн хэрэг хуримтлалын түүхэнд олон зууны явцад саад бэрхшээл тохиолдож байлаа. Герман улсад хоёр ч удаа мөнгөний уналт болж байсан. Гэсэн хэдий ч бид хуримтлуулсаар байсан. CoVid-19-ийн үед ч Германд хадгаламжийн хэмжээ хоёр дахин өссөн.

**МАНАЙ УЛСЫН ХУВЬД БАНКНЫ
ХАДГАЛАМЖИЙГ ИРГЭД ХЭР ӨНДӨР ХҮҮТЭЙ
БАЙГААГААС НЬ ХАРГАЛЗАН СОНГОДОГ.
ГЭТЭЛ ХӨГЖИНГҮЙ ОРОН БАЙХ ТУСАМ
ХАДГАЛАМЖИЙН ХҮҮ МАНАЙХААС ХЭД
ДАХИН БАГА БАЙДАГ ШҮҮ ДЭЭ. ТЭГЭХЭЭР
ТЭДГЭЭР ОРНЫ ИРГЭД ХАДГАЛАМЖИЙГ ЮУ
ГЭЖ ҮЗДЭГ ГЭСЭН ҮГ ВЭ?**

Европын орнуудад уламжлалт хадгаламжид хүү тооцохоо бараг больсон. Германд та банкны хадгаламжаасаа 0.01% хүү авбал өөрийгөө азтайд

тооцоорой. Учир нь банкууд эхнээсээ хасах хүүтэй болж эхлээд байна. Энэ нь харилцагч банканд мөнгөө хадгалуулсныхаа төлөө төлбөр төлнө гэсэн үг. Гэхдээ энэ дүр зураг Европод харилцан адилгүй л дээ, учир нь евро бүсийн улс орны ард түмэн бүрийн хадгаламжийн квот өөр, өөр байна.

Уламжлалт хадгаламж нь Германд хасах хүүтэй байгаа гэдгийг өмнө хэлсэн. Германд хэдийгээр олон арилжааны банкууд байгаа ч Шпаркассэ банк харилцагчдын хувьд зах зээл дээр тэргүүлэх банк хэвээр байна. Хэдийгээр хамгийн орчин үеийнх нь биш ч гэсэн Шпаркассэ банкны олон зуун жилийн туршлага, ямар нэг асуудал үүсгэдэггүй эерэг имидж нь харилцагчдыг өөртөө татах нэг шалтгаан болдог юм. Маш олон жилийн туршлага, найдвартай байдал, ажилтнуудын ур чадвар нь давуу тал болдог.

**ТА МОНГОЛД АЖИЛЛААД УДААГҮЙ Ч
МОНГОЛООР ЦӨӨНГҮЙ ҮГ СУРЧ АВСНЫГ БИ
ХЭДЭНТЭЙ СОНССОН. ТЭГЭХЭЭР МОНГОЛД
НЭЛЭЭД ДАСАЖ БАЙГАА БАЙХ. БИДНИЙ
ЯРИАНЫ СЭДВИЙН ХҮРЭЭНД СОНИРХОХОД,
МОНГОЛЧУУДЫН МӨНГӨТЭЙ ХАРЬЦАЖ БҮЙ
БАЙДАЛД ТА АЖИГЛАЛТ ХИЙЖ АМЖСАН УУ?**

Монголд хуримтлал үүсгэх тухай ойлголт харьцангуй шинэ байна гэж харж байна. Энэхүү аугаа улсын олон зуун жилийн түүхтэй харьцуулахад хуримтлал/хадгаламж бий болгох тухай ойлголт нь бүр ч залуу юм! Ахмад үеийнхэн бэлэн мөнгийг илүүд үзсээр байгаа нь хадгаламж үүсгэх боломж байгаагүй, үүндээ ч дасчихсан байж болох юм. Харин Монголын хүн амын нэлээд хувийг эзэлдэг залуу үеийнхний тухайд тэдний дунд зээлийн эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч Монголчууд орлогынхоо тодорхой хэсгийг хуримтлуулахыг хичээдэг. Энэ бол маш чухал зүйл гэж бодож байна. Учир нь тогтмол хуримтлуулснаар та хэцүү цаг үед санхүүгийн эрсдэлээс зайлсхийж чадахаас гадна хамгийн чухал нь ирээдүйн хүслээ биелүүлэх юм шүү. Хүн болгонд хүсэл мөрөөдөл, хүсэл эрмэлзэл байдаг, гэхдээ зөвхөн хуримлуулж байж л үүнийгээ бодит болгох боломжтой. Бага багаар хуримтлуулахын тулд Монголчуудад багахан сайжруулалт хийх боломж байсаар байна гэж би бодож байна. Учир нь энд хадгаламжийн хүү маш өндөр байна. Мөн юу маш чухал вэ гэхээр

Монголд цөөхөн хүмүүс л 20 сая хүртэлх төгрөгийн хадгаламжийг Хадгаламжийн Даатгалын Корпораци-д даатгуулах боломжтой гэдгийг мэддэг юм шиг санагдсан.

**ШПАРКАССЕ БАНКНЫ МОНГОЛ ДАХЬ
САНГААС МАНАЙ УЛСЫН ОЛОН НИЙТИЙН
БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ СУРГАЛТАД
ЗОРИУЛСАН ЖИЖИГ ОВРЫН АВТОБУС
БЭЛЭГЛЭСЭН ШҮҮ ДЭЭ. ҮҮНИЙГ ОРОН
НУТГИЙН БОЛОН АЛСЛАГДСАН БҮС НУТГИЙН
ИРГЭДЭД ХҮРЧ ҮЙЛЧЛЭЭСЭЙ ГЭЖ ЗОРИУЛСАН
БАЙХ. МАНАЙ УЛС ҮҮНД ХЭРХЭН АНХААРЧ
БАЙГАА ТАЛААР ТА ЯМАР БОДОЛ ТЭЭДЭГ ВЭ?**

Олон нийтэд санхүүгийн суурь анхан олгох чиглэлээр олон байгууллага, арилжааны банкууд, юун түрүүнд Төв банк маш их зүйл хийж байгаа гэж бодож байна. Нэмж хэлэхэд, Германы Шпаркассэ банкны сангийн хувьд бараг бүхий л талыг өөрсдийн туршлага, сургалтын концепцоор дэмжин ажиллаж байгаа юм. Өмнө хэлсэнчлэн, сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаснаар илүү сайжрах боломжтой. Ийм олон зүйл энэ чиглэлээр хийгдэж байгаад Монголчууд бахархах хэрэгтэй болов уу. Гэхдээ мэдээж илүү сайн байлгах боломжтой. Тиймээс Германы Шпаркассэ банкны зүгээс Төв банканд “Санхүүгийн боловсролын автобус” нэртэй бага оврын автобус бэлэглэсэн юм. Автобус маань хөдөө талд ч сургалт хийх боломжийг бүрдүүлэх шаардлагатай хэрэглэгдэхүүнтэй учир санхүүгийн суурь боловсролыг алслагдсан хэсэгт ч очиж хүргэх боломж бүрдэж байна.

Ярилцлагаа энд хүргээд өндөрлөө.

Танд баярлалаа.



ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ (GMW)

Дэлхийн мөнгөний долоо хоног нь хүүхэд, залууст санхүүгийн боловсролын ач холбогдол, санхүүгээ зөв зохистой удирдахад шаардагдах мэдлэгийг зааж сургах болон сурталчлан таниулах зорилготой хөдөлгөөн юм. Тус хөдөлгөөнийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ээс зохион байгуулдаг.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ЗОРИЛГО

Дэлхийн мөнгөний долоо хоногийн эцсийн зорилго нь нийт хүүхэд, залуучуудад чанартай санхүүгийн боловсрол эзэмшүүлэх, мөнгөтэй холбоотой мэдлэгийг түгээх, санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах чадвартай болгоход орших юм. Үүний цаад ач холбогдол нь нийт улс орнуудын ирээдүйн санхүүгийн тогтвортой байдлын төлөөх үйлдэл билээ.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГИЙН АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уг хөдөлгөөнийг дэлхийн өнцөг булан бүрт байгаа хамтрагч байгууллагууд зохион байгуулдаг бөгөөд хоорондоо мэдээ мэдээлэл болон зохион байгуулсан арга хэмжээнүүдийн зургаа GMW хариуцсан ажилтанд хүргүүлдэг. Харин эдгээр бүх үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон GMW-ын албан ёсны вебсайтаар дамжуулан хооронд нь холбож өгдөг байна.

ХҮҮХЭД, ЗАЛУУСТ МӨНГӨНИЙ ТАЛААР БАГААС НЬ ЗААЖ СУРГАХ НЬ

Хүүхэд, залуучуудыг санхүүгийн боловсролтой болгохын тулд бага наснаас нь санхүүгийн зохистой дадал зуршилд сургаж, мөнгөний үнэ цэнийг ойлгуулснаар ирээдүйд санхүүгээ зөв удирдах боломжийг нь нээж өгдөг байна. Иймд ЭЗХАХБ-аас засгийн газрууд болон бусад оролцогч талуудад суралцагчдынхаа насны онцлогт тохирсон сэдвүүдээр дамжуулан "санхүүгийн боловсролыг аль болох бага наснаас нь зааж сургахыг" уриалдаг.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ ХЭЗЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ВЭ?

Дэлхийн мөнгөний долоо хоног нь жил бүрийн 3-р сард болдог.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ ХӨДӨЛГӨӨН НЬ АНХ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ

"Дэлхийн мөнгөний долоо хоног" хөдөлгөөн нь анх 2012 онд зохион байгуулагдаж эхэлснээс хойш нийт 175 улс орны 40,200,000 хүүхэд, залууст мөнгө болон түүний үнэ цэнийг ойлгуулж, 465,000 гаруй арга хэмжээг 63,000 хамтрагч байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулсан байна.

МОНГОЛ УЛС АЛБАН ЁСООР ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2021 АЯНД НЭГДСЭН

Манай улс “Дэлхийн Мөнгөний Долоо Хоног-2021” аяны нээлтийг 3-р сарын 22-ны өдөр цахимаар хийлээ. Энэ жил “Суралц-Хуримтлуул-Өсгө” уриан дор болов. Хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготойгоор жил бүр тус аяныг зохион байгуулдаг.

Монголбанкнаас 2013 оноос холбогдох байгууллагуудтай хамтран тэмдэглэж ирсэн билээ.



МОНГОЛ УЛСАД УГ АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ БАЙГУУЛЛАГУУД

Аяныг Монголбанк, БШУЯ, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын Банкны Холбоо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан болон арилжааны банкууд хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр байгууллагууд хамтдаа “Мөнгөө хэрхэн удирдах вэ”, “Хувь хүний санхүү ба өрхийн төсөв”, “Зардал ба хуримтлал”, “Цахим мөнгө” зэрэг сэдвээр сургалтууд зохион байгуулж, олон нийтэд мэдээлэл, сургалтыг өгч ажиллаж ирэв.

“ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ”-ИЙГ

МОНГОЛ УЛСАД ТЭМДЭГЛЭСЭН ОН ЦАГИЙН ТОВЧООН

